

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/001/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Намжил
Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл.....
 - 4.2 Материаллаг байдал.....
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НББОУС | Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

“УЛААНГОМЫН ДУЛААНЫ
ХОЁРДУГААР СТАНЦ” ТӨХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.АНХБАЯР ТАНАА

2026.03.12 № УВА-2026/001/НА-СТА-ТӨВГ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050678

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

5.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Үлдэгдэл | |
|---------------|---|-------------------|-------------------|
| | | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| А | Б | 1 | 2 |
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 187,944,309.71 | 58,291,675.81 |
| 1.1.2 | Дансны авлага | 381,674,539.03 | 1,080,913,577.33 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 0.00 | 431,366.9 |
| 1.1.4 | Бусад авлага | 13,492,411.83 | 9,736,410.83 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | - | - |
| 1.1.6 | Бараа материал | 446,260,192.75 | 4,694,081,927.63 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 95,182,329.09 | 7,997,420.00 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | - | - |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | 0.00 | 0.00 |
| 1.1.10 | | | |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 1,124,553,782.41 | 5,851,452,378.50 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 15,346,104,690.08 | 21,899,859,569.40 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 497,740,000.00 | 497,740,000.00 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | - | - |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | - | - |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | - | - |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | - | - |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | - | - |
| 1.2.9 | | | |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 15,843,844,690.08 | 22,397,599,569.40 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 16,968,398,472.49 | 28,249,051,947.91 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | Өр төлбөр | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 151,262,028.21 | 497,915,763.26 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 0.00 | 0.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 144,086,862.07 | 398,113,166.31 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 62,700.60 | 0.00 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | - | - |
| 2.1.1.6 | Хүүгийн өглөг | - | - |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | - | - |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 9,968,848.53 | 29,460,402.69 |
| 2.1.1.9 | Нөөц (өр төлбөр) | - | - |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 26,938,820.21 | 9,397,000.00 |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр | - | |
| 2.1.1.12 | | | |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 332,319,259.62 | 934,886,332.26 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | - | - |
| 2.1.2.2 | Нөөц (өр төлбөр) | - | - |

| | | | |
|---------|-------------------------------------|--------------------|--------------------|
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | - | - |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | - | - |
| 2.1.2.5 | | | |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | - | - |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 332,319,259.62 | 934,886,332.26 |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 18,949,779,894.47 | 18,949,779,894.47 |
| 2.3.2 | - хувийн | - | - |
| 2.3.3 | - хувьцаат | - | - |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | - | - |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | - | - |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 161,243,643.48 | 161,243,643.48 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 492,449,793.06 | 9,354,030,553.46 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (2,967,394,118.14) | (1,150,888,475.76) |
| 2.3.10 | | | |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 16,636,079,212.87 | 27,314,165,615.65 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 16,968,398,472.49 | 28,249,051,947.91 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---------------|---|--------------------|--------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 5,354,992,751.31 | 7,628,066,400.16 |
| 2 | Борлуулалтын өртөг | 6,484,172,637.23 | 8,096,771,338.11 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | (1,129,179,885.93) | (468,704,937.94) |
| 4 | Түрээсийн орлого | - | - |
| 5 | Хүүгийн орлого | 1,423,830.18 | 38,976,055.66 |
| 6 | Ногдол ашгийн орлого | - | - |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| 8 | Бусад орлого | - | - |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 174,152,883.19 | 232,883,759.43 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 1,069,383,302.31 | 1,441,194,334.79 |
| 11 | Санхүүгийн зардал | - | - |
| 12 | Бусад зардал | 1,811.40 | - |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | - | - |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | - | - |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | 2,992,072,309.09 | 5,456,899,584.07 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 620,778,256.44 | 3,353,092,607.57 |
| 19 | Орлогын татварын зардал | 62,077,825.64 | 335,309,260.76 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | 558,700,430.79 | 3,017,783,346.81 |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 558,700,430.79 | 3,017,783,346.81 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| | Бусад олз (гарз) | - | - |
| 24 | Орлогын нийт дүн | 558,700,430.79 | 3,017,783,346.81 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | - |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | Нийт дүн |
|--|-------------------|-------------------------------------|---------------------------|-------------------------------|--------------------|
| 2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл | 13,175,741,444.47 | 161,243,643.48 | 6,266,488,243.06 | (3,618,299,995.34) | 15,985,173,335.67 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | 92,205,446.40 | 92,205,446.40 |
| Залруулсан үлдэгдэл | 13,175,741,444.47 | 161,243,643.48 | 6,266,488,243.06 | (3,526,094,548.94) | 16,077,378,782.07 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | 558,700,430.79 | 558,700,430.79 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - |
| Өмчид гарсан өөрчлөлт | 5,774,038,450.00 | - | (5,774,038,450.00) | | |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - |
| 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 18,949,779,894.47 | 161,243,643.48 | 492,449,793.06 | (2,967,394,118.14) | 16,636,079,212.87 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | (1,201,277,704.43) | (1,201,277,704.43) |
| Залруулсан үлдэгдэл | 18,949,779,894.47 | 161,243,643.48 | 492,449,793.06 | (4,168,671,822.57) | 15,434,801,508.44 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | 3,017,783,346.81 | 3,017,783,346.81 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | 8,861,580,760.40 | | 8,861,580,760.40 |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - |

| | | | | | |
|-------------------------------------|-------------------|----------------|------------------|--------------------|-------------------|
| 2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 18,949,779,894.47 | 161,243,643.48 | 9,354,030,553.46 | (1,150,888,475.76) | 27,314,165,615.65 |
|-------------------------------------|-------------------|----------------|------------------|--------------------|-------------------|

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---------------|--|------------------|--------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 9,461,378,157.95 | 13,754,372,618.41 |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 6,153,022,915.95 | 7,684,815,586.04 |
| | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | - |
| | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | - | - |
| | Буцаан авсан албан татвар | - | - |
| | Татаас, санхүүжилтийн орлого | 3,067,753,300.00 | 5,732,000,000.00 |
| | Бусад мөнгөн орлого | 240,601,942.00 | 337,557,032.37 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 8,971,332,439.18 | 13,631,762,665.98 |
| | Ажиллагчдад төлсөн | 2,540,586,750.98 | 3,111,559,077.63 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 754,505,031.91 | 987,731,697.21 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 2,814,077,439.23 | 4,820,134,835.01 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 1,087,544,938.06 | 1,070,592,819.80 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 752,300,310.00 | 995,381,209.96 |
| | Хүүгийн төлбөрт төлсөн | - | - |
| | Татварын байгууллагад төлсөн | 829,660,785.85 | 1,021,503,619.75 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | 3,316,424.00 | - |
| | Бусад мөнгөн зарлага | 189,340,759.15 | 1,624,859,406.62 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 490,045,718.77 | 122,609,952.43 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 1,423,830.18 | 38,976,055.66 |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | - | - |
| | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | - |
| | Хүлээн авсан хүүгийн орлого | 1,423,830.18 | 38,976,055.66 |
| | Хүлээн авсан ноогдол ашиг | - | - |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 407,696,681.82 | 291,238,641.99 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 407,696,681.82 | 291,238,641.99 |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | - |
| | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | - | - |

/төгрөгөөр/

| | | | |
|-----|--|------------------|------------------|
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (406,272,851.64) | (252,262,586.33) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | - | - |
| | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| | Төрөл бүрийн хандив | - | - |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | - | - |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | - | - |
| | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | - | - |
| | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | - | - |
| | Төлсөн ногдол ашиг | - | - |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| 4.1 | Валютын ханшийн зөрүү | - | - |
| 4.2 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 83,772,867.13 | (129,652,633.90) |
| 5.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 104,171,442.58 | 187,944,309.71 |
| 5.2 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 187,944,309.71 | 58,291,675.81 |

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

"УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ" ТӨХЖ-ийн 2025 ОНЫ ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

| д/д | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2024 оны мөн үе | 2025 он 4-р улирал | | Өөрчлөлт (+өсөлт,-бууралт) | |
|---|---|-------------|--------------------|---------------------|---------------------|----------------------------|-------------------|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | өнгөрсөн оны мөн үеэс | төлөвлөгөөнөөс |
| 1 | Үйлдвэрлэсэн дулаан | мян.Гкал | 80.1 | 85.0 | 93.6 | 13.5 | 8.6 |
| | Шугамын алдагдал /биетээр/ | мян.Гкал | 4.01 | 4.25 | 4.68 | 0.7 | 0.4 |
| | /хувиар/ | хувь | 5.0 | 5.0 | 5.0 | - | - |
| | Борлуулсан дулаан | мян.Гкал | 76.1 | 80.8 | 88.9 | 12.8 | 8.2 |
| Нийт орлого : | | мян.төг | 8,348,488.9 | 13,074,373.8 | 13,123,942.0 | 4,776,463.1 | 49,668.2 |
| 2 | Үүндсэн үйл ажиллагааны орлого | мян.төг | 5,354,992.7 | 7,598,975.6 | 7,628,066.4 | 2,273,073.7 | 29,090.8 |
| | Үүнээс: Санхүүжилт /Улсын төсвийн татаас/ | мян.төг | 2,788,866.6 | 5,201,818.2 | 5,210,909.1 | 2,422,042.5 | 9,090.9 |
| | Санхүүжилт /Улаангом сумаас зуны ХХУ/ | мян.төг | 185,454.5 | 250,000.0 | 227,272.7 | 41,818.2 | (22,727.3) |
| | Үйл ажиллагааны бус орлого | мян.төг | 19,175.1 | 23,580.0 | 57,693.8 | 38,518.7 | 34,113.8 |
| Нийт зардал | | мян.төг | 7,727,710.7 | 9,794,511.1 | 9,770,849.4 | 2,043,138.7 | (23,661.7) |
| 3 | Үйл ажиллагааны зардал | мян.төг | 6,632,502.1 | 8,622,109.6 | 8,313,971.7 | 1,681,469.6 | (308,137.9) |
| | Үйл ажиллагааны бус зардал | мян.төг | - | 23,580.0 | - | - | (23,580.0) |
| | Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | мян.төг | 1,095,208.6 | 1,148,821.5 | 1,456,877.7 | 361,669.1 | 308,056.2 |
| 4 | Татварын өмнөх ашиг /алдагдал/ | мян.төг | 620,778.2 | 3,279,862.7 | 3,353,092.6 | 2,732,314.4 | 73,229.9 |
| 5 | Татварын дараах ашиг /алдагдал/ | мян.төг | 558,700.4 | 2,951,876.4 | 3,017,783.3 | 2,459,083.0 | 65,906.9 |
| 6 | Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал | төг | 1.44 | 1.29 | 1.28 | (0.16) | (0.008) |
| Нийт авлага : | | мян.төг | 396,166.9 | 99,200.0 | 1,091,081.4 | 695,914.5 | 991,881.4 |
| 7 | Үүнээс: ЭХ-ний | мян.төг | 380,674.5 | 99,200.0 | 1,079,913.6 | 699,239.1 | 980,713.6 |
| | Бусад | мян.төг | 14,492.4 | - | 11,167.8 | (3,324.6) | 11,167.8 |
| | Нийт өглөг : | мян.төг | 1,143,442.5 | 176,000.0 | 934,886.3 | (208,556.2) | 758,886.3 |
| 8 | Үүнээс: Урт хугацаат өр төлбөр | мян.төг | - | - | - | - | - |
| | Богино хугацаат өр төлбөр | мян.төг | 1,143,442.5 | 176,000.0 | 934,886.3 | (208,556.2) | 758,886.3 |
| 9 | Ажиллагсадын тоо | тоо | 96 | 100 | 97 | 1.0 | (3.0) |
| 10 | Нийт цалингийн сан | мян.төг | 2,823,231.4 | 3,741,303.8 | 3,717,170.0 | 893,938.6 | (24,133.8) |
| 11 | Жишмэл түлшний хувийн зарцуулалт | кг.Гкал | 255.4 | 260.3 | 236.3 | (19.1) | (24.0) |
| Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ | | тоо | 641,499.2 | 16,313,628.9 | 16,308,427.3 | 15,666,928.1 | (5,201.6) |
| 12 | Санхүүжилт 2025 он | мян.төг | | 4,615,228.9 | 4,610,027.3 | 4,610,027.3 | (5,201.6) |
| | 2026 он | мян.төг | | 11,698,400.0 | 11,698,400.0 | 11,698,400.0 | - |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компанийн үйл ажиллагаа

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК нь “Увс аймгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц дулааны эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, дулаан хангамжаар хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцөлийг хангахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх
- Дулаан түгээх
- Дулаанаар зохицуулалтай хангах

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Ашиглалтын өмнөх захиргаа нь 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр 60 хүний бүтэц орон тоотойгоор ажилчдыг авч халаалтын улирлыг эхлүүлэн үйл ажиллагаагаа жигдрүүлж, ажиллах хүч ажлын байрны тодорхойлолт, дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, бизнес төлөвлөгөө зэргийг гарган шинэ тутам байгууллагыг байгуулан ажиллаж байгаад 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдөр татан буугдсан.

Увс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/67 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын статустай байгуулагдсан “Дулааны хоёрдугаар станц, Дулааны шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн оноосон нэр бүхий гэрчилгээ авч 70 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж ажиллаж байгаад 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдөр татан буугдсан.

Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 202 дугаар тогтоолоор “Улаангомын дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрчим хүчний яам гэсэн хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг хэрэгжүүлэгч 9 гишүүнтэй бөгөөд тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь хараат бус гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

2025 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардалд нийт 163,774.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 138,284.7 мянган төгрөгийг зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин урамшууллын зардалд 121,150.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 12,744.5 мянган төгрөг, бичиг хэргийн материалын зардалд 755.8 мянган төгрөг, томилолтын зардалд 3,634.4 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн хувьд дараах хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр дүнтэй байна.

Эрчим хүчний сайдын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/271 дүгээр тушаалаар “Эрчим хүчний салбарт мөрдөгдөх дотоод аудитын аргачлал”-ыг баталсан байна.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн дотоод аудитор тайлант онд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/21 тоот тушаалаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр хүртэл айл өрхийн халаалтын талбайд стандартын дагуу хяналтын хэмжилт хийх, хэрэглээний халуун усны тоолуур шалгах, дулааны шугамыг стандарт шаардлагын дагуу татсан эсэхэд үзлэг шалгалт хийж зөрчлийг илрүүлж ажилласан.
- 2025 онд олгогдсон Техникийн нөхцөл, төлбөр хураамжийн төвлөрүүлэлтэд хяналт хийсэн.
- Концесс эзэмшигч Олон бригад ХХК, Дэвшил Увс ХХК-тай 2025-2026 оны халаалтын улиралд халаалт, хэрэглээний халуун усаар хангах гэрээ байгуулж, гэрээний хавсралтад айл өрх, аж ахуйн нэгж, төсөвт байгууллагын сард төлөх төлбөрийн мэдээллийг нэгтгэн талбайн хэмжилт хийж ажилласан.
- Монгол улсын эрчим хүчний яамнаас 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/4041 дугаар албан бичгийн хариутай бичгийг төлөвлөгөөний дагуу хяналт хийж хугацаанд нь хүргүүлсэн.
- Архив, албан хэрэг хөтлөлт: Улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж, удирдамжийн дагуу ажлыг зохион байгуулсан.
- Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан үнэ тарифын шийдвэрүүд хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт хийж ажилласан.
- Өндөр төлбөртэй айл өрх аж ахуйн нэгжийн орлого төвлөрүүлэлт дээр борлуулалтын ажилтантай хамтарч ажиллаж орлого төвлөрүүлж ажилласан 2 сард 1 удаа /200.0-аас дээш орлоготой айл өрх, 500.0-аас дээш төлбөртэй аж ахуйн нэгж/
- Шилэн дансны хэрэгжилтэд хяналт хийж ажилласан.
- Худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний хэрэгжилтэд дотоод аудит хийсэн.
- Хүний нөөцийн нөхөн дүүргэлт, сонгон шалгаруулалт, томилгооны үйл ажиллагааны процессыг хянан үнэлж, бодлогын дагуу хэрэгжилт, хууль, дүрэм журмыг мөрдөж байгаа эсэхэд хяналт хийсэн.
- Гүйцэтгэх захирлын тушаалаар хагас жил болон жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудиторын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус компани нь 2020 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд үйл ажиллагааны онцлогт нь тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

“Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,280,653.4 мянган төгрөгөөр буюу 66.5 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ |
|--|---------------------|---------------------|---------------------|
| | | | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 187,944.3 | 58,291.7 | -129,652.6 |
| Авлага | 395,167.0 | 1,091,081.3 | 695,914.3 |
| Бараа материал | 446,260.2 | 4,694,081.9 | 4,247,821.7 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 95,182.3 | 7,997.4 | -87,184.9 |
| Үндсэн хөрөнгө | 15,843,844.7 | 22,397,599.6 | 6,553,754.9 |
| Нийт хөрөнгө | 16,968,398.5 | 28,249,051.9 | 11,280,653.4 |
| Өр төлбөр | 332,319.3 | 934,886.3 | 602,567.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 16,636,079.2 | 27,314,165.6 | 10,678,086.4 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 16,968,398.5 | 28,249,051.9 | 11,280,653.4 |

Оны эхнээс мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 129,652.6 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд харилцах данс 58,263.6 мянга, касс 28.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын данс өмнөх оноос 176.1 хувиар буюу 695,914.3 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсөвт газраас авах авлага 473,480.3 мянган төгрөгөөр, аж ахуйн нэгжийн авлага 205,294.4 мянган төгрөгөөр, айл өрхийн авлага 20,464.4 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Бусад авлага 3,324.6 мянган төгрөгөөр буурсан байна. Сангийн яамнаас төсөвт байгууллагуудын 11, 12 сарын санхүүжилтийн эрх нээж өгөөгүй, төсвөөс санхүүжилт авдаг 2 аж ахуйн нэгжийн санхүүжилт олгоогүй нь голчлон нөлөөлсөн байна.

Бараа материалын үлдэгдэл 951.9 хувь буюу 4,247,821.7 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байна. Дуусаагүй үйлдвэрлэл дансанд Зуухны эх үүсгэврийн өргөтгөлийн ажлын гүйцэтгэлээрх санхүүжилтийн дүнг тусгасан болон нүүрсний нөөцийн үлдэгдэл гол нөлөө үзүүлжээ.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 7,997.4 мянган төгрөг болж өмнө оноос 87,184.9 мянган төгрөгөөр буурсан байна. Хотгор шанага ХХК-д төлсөн нүүрсний урьдчилгаа үнэ болох 1,091.4 мянган төгрөг, Увс аймаг Улаангом сум хөрөнгө оруулалтын барьцааны дансанд 6,906.0 мянган төгрөг төлсөнийг урьдчилж төлсөн зардал, тооцоо дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 41.4 хувиар буюу 6,553,754.9 мянган төгрөгөөр өссөн байна. 2025 онд худалдан авсан машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил 291,238.6 мянган төгрөгөөр, ТӨБЗГазарын 2025 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 714, 738 тоот

тогтоолуудын дагуу 8,532,691.9 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгө, улсын комиссын актаар 328,988.8 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгийг тус тус нэмж бүртгэсэн байна. 2025 оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нь 1,456,877.7 мянган төгрөг байна. ТӨБЗГ-ын тогтоолын дагуу хөрөнгө нэмж бүртгэсэнтэй холбоотой үндсэн хөрөнгийн үлдэгдэл өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 181.3 хувиар буюу 602,567.0 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд: Хартарвагатай ХК-нд төлөх нүүрсний үнийн өглөг 218,064.6 мянга, Цахилгаан түгээх сүлжээ ХХК-д төлөх цахилгааны өр төлбөр 120,934.0 мянга, татварын өр төлбөр 254,026.3 мянга, Урьдчилж орсон орлого 19,491.6 мянга, Бусад өглөг 561.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Ундарга Увс ХХК-д төлөх шатахууны үнийн өглөг 10,247.8 мянга, Нүүрсний тээврийн хөлс 200.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Татварын өр төлбөр өссөн нь компани 2025 оны жилийн эцсийн тайлангаар 3,353,092.6 мянган төгрөгийн ашигтай ажилласнаас ААНОАТ-ын 331,411.7 мянган төгрөгийн өр үүссэнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 64.2 хувиар буюу 10,678,086.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тухайн жил ашигтай ажилласан мөн хуримтлагдсан үр дүн, эзний өмчийн бусад хэсэг нэмэгдсэнээс шалтгаалжээ. Хуримтлагдсан үр дүн өсөхөд тайлант үеийн үр дүнгээс гадна Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол гарч 2019-2021 онд ашиглалтад авсан үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгах тухай шийдвэр ирүүлсний дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга 1,201,277.7 мянган төгрөг хийгдсэн зэрэг нөлөөлжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, ТУЗ-өөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2025 оны А/19 тушаалаар 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан ба тайлант оны нийт орлогыг 12,381,300.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 9,434,200.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 4,617,400.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Эрчим хүчний сайдын 2025 оны А/179 тушаалаар 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг өөрчлөн баталсан байна. Ингэхдээ тайлант оны нийт орлогыг 12,772,600.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 10,927,300.0 мянган төгрөгөөр, 1,845,300.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээг 4,583,200.0 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Мөн Эрчим хүчний сайдын 2025 оны А/278 тушаалаар 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг өөрчлөн баталсан байна. Ингэхдээ тайлант оны нийт орлогыг 13,074,400.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 9,794,500.0 мянган төгрөгөөр, 3,279,900.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээг 4,615,200.0 мянган төгрөгөөр дахин тодотгосон байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 13,123,942.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 9,770,849.4 мянган төгрөгийн зардал гарган, 3,017,783.3 мянган төгрөгийн татварын дараах ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 13,123,942.0 мянган төгрөг болж төлөвлөснөөс 49,568.2 мянган төгрөг буюу 100.4 хувиар давсан биелэлттэй байна. Энэ нь борлуулалтын орлого

29,090.8 мянган төгрөгөөр, Эрчим хүчний яамнаас татаас санхүүжилтийн орлого 9,090.9 мянган төгрөгөөр, бусад орлого 11,386.5 мянган төгрөг нэмж орж ирсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 9,770,849.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 23,661.7 мянган төгрөг буюу 0.2 хувиар хэмнэсэн гүйцэтгэлтэй байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу нэг төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 4,610,027.3 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 3,017,783.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 65,906.9 мянган төгрөгөөр өссөн нь орлогын гүйцэтгэл нэмэгдэж зардал буурсантай холбоотой байна.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

| | | | | | /мянган төгрөг/ |
|---|---|-------------|-------------|----------|--|
| № | Үзүүлэлт | Төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | Тайлбар |
| 1 | Программ хангамжийн бүртгэл | | 23,036.4 | | Санхүүгийн тайлан гаргах Апекс 1.21.88.176, борлуулалтын тайлан гаргах ABIS программ |
| 2 | Унаа, хоолны зардал | 117,600.0 | 151,340.5 | 33,740.5 | Хоолны зардал 1 хүнд өдөрт 7,500 төгрөг |
| 3 | Сургалт, семинар | | 0.0 | | Зардал гараагүй. |
| 4 | Гадаад томилолт, арга хэмжээ | 2,430.1 | 2,430.1 | | Зуухны өргөтгөлийн эх үүсвэрийн ажлаар ОХУ-д 1 ажилтан явсан. |
| 5 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал | | 0.0 | | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна. |
| 6 | Орон тооны цомхотгол | 3,741,303.8 | 3,717,170.0 | 24,133.8 | Гүйцэтгэлээр 3 орон тоо дутуу ажилласан байна. |
| 7 | Хэвлэл, мэдээлэл | | 300.0 | | Нэг удаагийн видео бичлэг хийсэн болон зар сурталчилгааны зардал |
| 8 | ТӨҮГ-ын судалгаа | 3,279,862.7 | 3,353,092.6 | 73,229.9 | Төлөвлөгөөт орлого 49,568.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн болон зардал 23,661.7 төгрөгөөр буурсан нь ашиг 73,229.9 мянган төгрөгөөр өсөх шалтгаан болсон байна. |

3.5.1 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК нь 2025 онд Нээлттэй тендер шалгаруулалт 4, харьцуулалтын аргаар 7, нийт 11 тендер худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан байна. 33 ажлыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан байна.

Тендер худалдан авах ажиллагааг 7 удаа зарласан боловч оролцогч материал ирүүлээгүй 2 ажилд шууд гэрээ байгуулсан, Сангийн яаманд гомдол гаргаж шийдвэрлүүлсэн 2 ажил байна. Үүнд:

- ❖ Нүүрсний зардал /Нүүрс худалдан авах/ тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 09 дүгээр сарын 03-ны өдөр хүртэл нийт 7 удаа зарлаад амжилтгүй болсон. Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах, нүүрсний нөөц дууссан халаалтын улирал эхлэсэн

зэрэг нөхцөл байдал үүссэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35.1.2 дахь заалтыг үндэслэн Хартарвагатай ХХК-тай гэрээ байгуулсан байна. Ингэхдээ хуулийн 48.7 дахь зүйлийг үндэслэн гэрээг Авилгатай тэмцэх газарт хүргүүлсэн байна.

- ❖ Нүүрс тээврийн тендерийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл 7 удаа зарлаад амжилтгүй болсон. Нүүрсний нөөц дууссан, өвөлжилтийн бэлтгэл ажил хангах, Халаалтын улирал эхлэсэн зэрэг нөхцөл үүссэн тул төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35.1.2-ийг үндэслэн 7 компани, 13 хувь жолооч нартай гэрээ байгуулсан байна.
- ❖ Суурин компьютер, нөтбүүк, принтер нийлүүлэх худалдан авах ажиллагаанд оролцогч Микросити ХХК, Сүүнхүнгий ХХК-ууд Сангийн яаманд гомдол гаргасан байна. Сангийн яамнаас гомдол үндэслэлгүй гэсэн хариу ирж тендерийг үргэлжлүүлж Голден хоул ХХК-ийг шалгаруулж гэрээ байгуулжээ.
- ❖ Хөдөлмөр хамгааллын бээлий, маск нийлүүлэх худалдан авах ажиллагаанд оролцогч “Харцал харгиа” ХХК нь захиалагчийн шийдвэр хянан үзэхийг хүссэн гомдол Сангийн яаманд гаргасан байна. Хуулийн 59-р зүйлийн 59.10.2 дахь заалтад үндэслэн тендер шалгаруулалтын тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдсэн хариу ирүүлсний дагуу дахин зарласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК 2025 оны санхүүгийн тайлангаа Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт борлуулалтын өртөгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Их” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт борлуулалтын өртөг 6,484,172.6 мянган төгрөгийн 0.5 хувиар буюу 32,420.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 25,936.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт борлуулалтын өртөг 8,096,771.3 мянган төгрөгийн 0.5 хувиар буюу 40,483.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 32,387.1 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн хуулийн “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-д хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 155, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 124,400.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитаар өгсөн | | Биелэлт | | |
|-----------------|----------------------|-----------|---------|-----------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 124,400.0 | 1 | 124,400.0 | 100 |

/мянган төгрөгөөр/

| | | | | | |
|-----------------|----------|------------------|----------|------------------|------------|
| Зөвлөмж | | | | | |
| Нийт дүн | 1 | 124,400.0 | 1 | 124,400.0 | 100 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сахилгын шийтгэлтэй хүнд сарын болон жилийн урамшуулал олгохдоо “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан Компани ажилтнуудад “Жилийн болон сарын ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалин олгох журам”-ыг баримталж байна. Журмын 3.2-д “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл хүлээсэн ажилтанд тухайн сарын ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгохгүй” гэж заасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 дахь хэсэгт “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасанд нийцэхгүй байна. Иймд хууль, журамд нийцүүлэн “Жилийн болон сарын ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалин олгох журам”-д өөрчлөлт оруулсан эсэхийг дараагийн аудитаар давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,410.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

5.2 Зөвлөмж

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК нь Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаж шууд гэрээгээр гүйцэтгэсэн Хөдөлмөр хамгааллын хувцас авах ажлын санхүүжилтийг төлөвлөгснөөс нэмж хувцас авсантай холбоотойгоор 1,740.0 мянга, Галын цемент нийлүүлэх ажлын санхүүжилтийг төлөвлөснөөс нэмж авсантай холбоотойгоор 1,800.0 мянга, Димсосын хөдөлгүүр 75кВт ажлын санхүүжилтийг гүйцэтгэгч тухайн өртгөөр гүйцэтгэх боломжгүй гэсэн хүсэлт ирүүлсний дагуу 870.0 мянга, нийт 4,410.0 мянган төгрөгөөр өсгөж гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.8 дахь хэсэгт “Хэлэлцээгээр техникийн тодорхойлолт, санхүүжилтийн болон гэрээний нөхцөлийн талаар мэдээллийг солилцоно” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан төсөвт өртгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|---------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруула агүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|---------|---------------|-----|-----------------|-----|---------|---------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний үнийг баримтлаагүй | 1 | 4,410.0 | | | | | 1 | 4,410.0 | | | | |
| Дүн | 1 | 4,410.0 | | | | | 1 | 4,410.0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.НАМЖИЛ/

2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр